



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД Ц.ИДЭРБАТ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.09.17 № 61

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн
хэрэгжилтийн талаар

Органик хүнс, түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, төрөөс органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, экспортыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдол бүхий Органик бүтээгдэхүүний тухай хуулийг 2024 онд баталж, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдсөн.

Монгол Улс 2030 он гэхэд хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 5 хувь органик баталгаажуулалтад хамрагдсан байх зорилт тавьсан. Гэвч органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2025 оны байдлаар 1 хувьд ч хүрэхгүй байна. Өөрөөр хэлбэл органик бүтээгдэхүүний борлуулалтын орлого 2025 оны сүүлийн байдлаар 242 сая төгрөг буюу нийт хүнсний боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтын дүнтэй харьцуулахад 1,2 хувь, органик хүнсний ногооны тариалалтын талбайн хэмжээ 76,2 га буюу нийт хүнсний ногооны тариалалтын талбайн 0,4 хувийг эзэлж байна.

Органик бүтээгдэхүүний тухай хуульд төрөөс үзүүлэх дэмжлэгүүдийг нарийн тусгаж өгсөн ба түүнийг хэрэгжүүлснээр байгаль орчин, эко систем, хүний эрүүл мэндэд ээлтэй органик үйлдвэрлэл хөгжиж, зах зээлд өрсөлдөх чадвар сайжирч, бүс, орон нутгийг хөгжүүлэх, орон нутагт ажлын байр бий болгох, органик хүнс, бүтээгдэхүүнээр хүн амаа хангах, экспортод гарах боломж бүрдэх эх үүсвэр тавигдах юм. Гэтэл органик бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс судалгаа авахад оролцогчдын дийлэнх нь төрөөс олгож буй хөнгөлттэй зээлийн шалгуур өндөр, татвар, шимтгэлийн нөхцөл уян хатан бусаас гадна хэрэглэгчдийн органик бүтээгдэхүүний талаарх мэдлэг дутмагаас зах зээлийн тогтвортой тогтолцоо бүрдээгүй зэргээр хуулийн хэрэгжилт хангалтгүй хэрэгждэг гэсэн дүгнэлт гарсан байна.

Иймд Органик бүтээгдэхүүний тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарч буй хүндрэл бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна.

1.Хууль батлагдсанаар журам 14, аргачлал, жагсаалт 2, баталгаажуулалтын гэрчилгээ болон дотоод хяналтын хуудасны загвар, мэдээллийн санд хэрэглэгчээр бүртгүүлэх маягтын загварыг батлан хэрэгжүүлэх ёстой. Эдгээрээс 2025, 2026 онд батлагдсан журам, загвар болон батлагдаагүй хэм хэмжээний актуудын талаар холбогдох тайлбар мэдээлэл;

2.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан олон улсын байгууллагын гишүүнчлэлийн төлбөр, органик бүтээгдэхүүнийг экспортлоход зориулсан

2026000179

хөрөнгө оруулалтад зориулан арилжааны банкнаас авсан зээлийн 50-иас доошгүй хувийг төрөөс хүүгийн дэмжлэг үзүүлэх, органик бүтээгдэхүүнтэй холбогдох мэдээлэл, сургалт, сурталчилгааг улсын төсвөөс санхүүжүүлэх, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн аж ахуйн нэгжийн орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсэн эхний таван жилд 100 хувиар, дараагийн таван жилд 50 хувиар хөнгөлөх заалт, шилжилтийн үеийн баталгаажуулалтын зардал, органик бордоо худалдан авсан эхний 3 жилийн зардлыг тус тус төрөөс санхүүжүүлэх бэлтгэл ажил хийгдэж байгаа эсэх, мөн сургуулийн хоол үйлдвэрлэлийн нэгж нь Ерөнхий боловсролын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасны дагуу органик бүтээгдэхүүнийг хэрхэн хэрэглэж байгаа зэрэг заалтуудын хэрэгжилтийн талаарх судалгаа мэдээлэл;

3.ХХААХҮЯ-ны өмчлөлд бүртгэлтэй байгаа органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдгийн "органик хүнс" гэснийг "органик бүтээгдэхүүн" болгох шийдвэрийн хэрэгжилт;

4.Хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний баталгаажуулалт зохих журмын дагуу хийгдэж байгаа эсэх;

5.Органик бүтээгдэхүүн болон талбайн талаарх судалгааны явц, мэдээллийн сан бүрдүүлэлтийн талаарх мэдээлэл;

6. Органик бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх хүрээнд олон улсад монголын гаралтай органик бүтээгдэхүүний баталгаажуулалтыг харилцан хүлээн зөвшөөрөх, хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулахад яамны зүгээс хийж буй ажлын талаар;

7."органик", "байгалийн цэвэр", "байгалийн гаралтай цэвэр", "эко", "ногоон", "экологийн гаралтай", "экологийн цэвэр", "экологийн" "био", "биологийн", "биологийн гаралтай", "биологийн цэвэр" гэсэн үгийг монгол болон гадаад хэлээр түүхий эд бүтээгдэхүүний шошгод байршуулах, хуулийн этгээдийн нэрээр баталгаажуулсан эсэх асуудлыг судлан шийдвэрлэх, хянах тогтолцоог хэрхэн бүрдүүлж байгаа талаар;

8.ХХААХҮЯ-ны дэргэд органик салбарын Үндэсний зөвлөл, ХХААХҮ-ийн судалгаа хөгжлийн төвд органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх судалгааны нэгж байгуулах, аймаг, нийслэлийн Засаг дарга органик үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөртэй байх асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар;

9.Хүнсний тухай хууль болон Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн шинэчлэлт, хүнсний аюулгүй байдлын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх талаар хийгдэж буй ажил, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээлэл;

10.Хэрэглэгчдэд хэрэглээний боловсрол эзэмшүүлж, хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэх, худалдааг дэмжих зорилгоор хийж буй ажлын талаарх мэдээлэл.

Дээрх асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд ирүүлэхийг хүсье. Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байгаа болно.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Ч.УНДРАМ

2026000179